**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 22 өдөр | Дугаар А/408 | Есөнбулаг сум

Төв суурин газрын өвөлжилтийн
бэлтгэлийг хангах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2025-2026 оны төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг хавсралтаар батлсугай.

2.Бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гаргаж, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулж хэрэгжилтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

3.Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, хамтран ажиллахыг албан байгууллагын дарга, захирал, эрхлэгч, сумдын дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Д.Буянхишиг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025

Аймгийн Засаг даргын 2025 оны
07...дугаар сарын 22. -ны өдрийн
А/408..дугаар захирамжийн хавсралт

ТӨВ СУУРИН ГАЗРЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ
ХАНГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | (Аймгийн Засаг даргын орлогч) |
| Нарийн бичгийн дарга: | (Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга) |
| Гишүүд: | (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга) |
| | (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга) |
| | (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга) |
| | (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга) |
| | (Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга) |
| | (Онцгой байдлын газрын дарга) |
| | (Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга) |
| | (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн) |
| | ("Алтай-Улиастайн Эрчим Хүчний систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал) |
| | ("Ундарга-Алтай" ААТҮГ-ын захирал) |
| | ("Солонго дулааны станц" ААТҮГ-ын захирал) |
| | ("Мандал-Голомт" ХХК-ийн захирал) |
| | ("ГАА-АЗЗА" ТӨХК-ийн захирал) |
| | (Сумдын Засаг дарга нар) |
| | (Сумдын дулаанаар хангагч байгууллагууд) |

__ oOo __

ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ᠂ ᠰᠣᠶᠣᠯ - ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ ᠤᠬᠠᠭᠠᠨ ᠤ
ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ

᠒᠐᠐᠗ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠒ ᠡᠳᠦᠷ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠒᠐᠕ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒᠔.᠒᠂ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 7 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 7.᠑.᠙᠂ ᠳᠡᠭᠡᠳᠦ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠖.᠑ ᠳᠦ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠬᠤ ᠨᠢ :

᠑ .. ᠢᠯᠡᠭᠦᠦ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠒᠐᠐᠗-᠒᠐᠐᠘ ᠣᠨ ᠤ ᠬᠢᠴᠢᠶᠡᠯ ᠦᠨ ᠵᠢᠯ ᠳᠦ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠶᠣᠰᠣᠭᠠᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠭᠠᠷᠠᠢ ..

᠒ .. ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠬᠦ ᠪᠡᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠳᠤ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠨᠤᠭᠤᠳ ᠤᠨ ᠒᠐᠐᠗ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠘ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠰᠢᠢᠳᠪᠦᠷᠢ ᠶᠢ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠶᠣᠰᠣᠭᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ (ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ-᠑) ᠪᠡᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠭᠠᠷᠠᠢ ..

᠓ .. ᠲᠣᠭᠲᠠᠭᠰᠠᠨ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠨᠤᠭᠤᠳ ᠲᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠵᠦ᠂ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠬᠢᠨᠠᠬᠤ ᠶᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ᠂ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠨᠠᠷ ᠲᠤ ᠳᠠᠯᠠᠯᠭᠠᠰᠤᠭᠠᠢ ..

᠔ .. ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠶᠢ ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠨᠠᠷᠢᠯᠠᠭ ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ (ᠪ.ᠪᠠᠲᠤᠬᠦᠦ) ᠳᠦ ᠳᠠᠯᠠᠯᠭᠠᠰᠤᠭᠠᠢ ..

ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠣᠷᠣᠯᠠᠭᠴᠢ [signature] ᠬᠣ. ᠰᠠᠨᠳᠠᠭᠰᠦᠷᠡᠩ